



## **“ҮНДЭСТЭН ЖЕНЕРАЛ ИНШУР” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Энэхүү журмын зорилго нь “Үндэстэн Женерал Иншур” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд Компанийн тухай хууль, дүрмээр олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага бөгөөд хуулийн хүрээнд компанийн дүрэмд нийцсэн үйл ажиллагаа явуулах, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг бэлтгэж зохион байгуулах, хууль, дүрэмд заасан асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргах, биелэлтэд хяналт тавих, гишүүдийн санаачлага, үр бүтээлтэй ажиллах нөхцөл бүрдүүлэх, хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг гүйцэтгэнэ.
- 1.3. Зөвлөл нь үйл ажиллагаандаа зах зээлийн шударга зарчмыг нэвтрүүлэх, компани, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, бүрэн эрхийнхээ асуудлыг хамтран хэлэлцэж, дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэх зарчмаар ажиллаж, хувьцаа эзэмшигчдийн өмнө хамтын хариуцлага хүлээж ажиллана.
- 1.4. Зөвлөл нь үйл ажиллагааны бодлого, чиглэл, үр дүнг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулна.

### **Хоёр. Төлөөлөн удирдах зөвлөл ба хурал**

- 2.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байна.
- 2.2. Компанийн ТУЗ-ийн гишүүдийн тоо нь Компанийн тухай хууль болон Компанийн дүрэмд зааснаар 5 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 1 багагүй нь хараат бус гишүүн байна.
- 2.3. ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа нь 3 жил бөгөөд улируулан сонгож болно.
- 2.4. ТУЗ нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хурал хийж, тогтоол гаргах бөгөөд улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд ТУЗ нь харилцаа холбооны техник хэрэгслийг ашиглан хуралдах эсхүл эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.
- 2.5. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хурал хүчин төгөлдөр болох бөгөөд Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хуралд оролцож буй гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.
- 2.6. Хэрэв тухайн асуудлаар ТУЗ-ийн зарим гишүүн санал өгөх эрхгүй бол энэ талаар бусад гишүүдэд мэдэгдэж, хурлын протоколд тэмдэглэх ба шийдвэрийг саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ.
- 2.7. ТУЗ-ийн тогтоолд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хурлын тэмдэглэлд ТУЗ-ийн гишүүд гарын үсэг зурна.
- 2.8. ТУЗ-ийн гишүүн тус бүр хуралд саналын нэг эрхтэй оролцоно.
- 2.9. Компанийн гүйцэтгэх удирдлага улирал бүрийн ТУЗ-ийн хуралд Компанийн үйл ажиллагааны талаарх тайланг ТУЗ-ийн гишүүдэд танилцуулна.
- 2.10. ТУЗ-ийн хурлаар асуудал шийдвэрлэхэд гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд уг асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэх эсэх талаар санал хураахыг ТУЗ-ийн дарга санаачлах эрхтэй.

### **Гурав. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх**

- 3.1 ТУЗ нь Компанийн тухай хууль болон Компанийн дүрэмд зааснаас гадна дараах бүрэн эрхтэй байна. Үүнд:
- 3.1.1. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох;
  - 3.1.2. ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон Компанийн засаглалын дотоод журмыг батлах;
  - 3.1.3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлын бүртгэлийн өдрийг тогтоох, бүртгэлийн өдрөөс хойш хувьцаа худалдан авсан этгээдийг хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд оруулах эсэхийг шийдвэрлэх;
  - 3.1.4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлын саналын хуудасны агуулга, загварыг тогтоох, уг хурал болох огноо, газар, эхлэх цаг, бөглөсөн саналын хуудсаа илгээх хаяг, саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрийг тогтоох эрхтэй;
  - 3.1.5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлын зарыг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмуудад нийцүүлэн олон нийтэд зарлах;
  - 3.1.6. ТУЗ-ийн гишүүд нь аливаа шийдвэр гаргахын өмнө уг асуудалтай холбоотойгоор шаардлагатай мэдээллийг Компанийн гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнаас шаардаж авах эрхтэй байна;
  - 3.1.7. ТУЗ-ийн гишүүд нь шаардлагатай тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулт өгөх үүрэгтэй байна;

**Дөрөв. Төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох, гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох**

- 4.1. ТУЗ-ийн гишүүн нь Компанийн дүрэмд заасан шаардлагыг хангасан этгээд байх бөгөөд 3 жилийн хугацаагаар хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилно.
- 4.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас хамгийн олон тооны санал авсан нэр дэвшигчдийг ТУЗ-ийн гишүүнээр сонгогдсонд тооцно.
- 4.3. ТУЗ-ийн нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо нь Компанийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид сонгон шалгаруулалт хийж, шалгарсан этгээд нь энэ журмын 4.1-т заасан шаардлагыг хангаж буй эсэх талаар дүгнэлт гаргаж ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх бөгөөд ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар томилно.
- 4.4. Компанийн тухай хуулийн 77.4-д заасны дагуу ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг сонгох саналыг тус тусад нь тоолох ба Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон санал хураах кумулятив аргыг мөрдлөг болгоно.
- 4.5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрээр ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож болох бөгөөд ТУЗ-ийг зөвхөн бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг нь дуусгавар болгоно.
- 4.6. Удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлж чадахгүй болсон эсхүл нас барсан ТУЗ-ийн гишүүнийг орлох этгээдийг ТУЗ нөхөн сонгууль явуулах хүртэл түр томилж болно.
- 4.7. ТУЗ-ийн гишүүдийн тоо нь тогтоосон нийт гишүүдийн тооноос хоёр дахин бага болсон тохиолдолд ТУЗ нь гурван сарын дотор ТУЗ-ийн гишүүдийг сонгохоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулна.

**Тав. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн**

- 5.1. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь Компанийн дүрэмд заасан шаардлагыг хангасан этгээд байна.
- 5.2. ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг хангасан этгээдийг Компанийн ТУЗ-ийн нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооноос нэрийг нь дэвшүүлж Хувьцаа эзэмшигчдийн хурлаас батална.



- 5.3 ТУЗ-ийн хараат бус гишүүн нь сайн дурын үндсэн дээр нэрээ дэвшүүлэх бөгөөд энэхүү зөвшөөрлөө бичгээр өгсөн байна.
- 5.4 ТУЗ-ийн хараат бус гишүүн нь ТУЗ-ийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэхэд зайлшгүй саналаа өгсөн байна. Үүнд:
- 5.4.1 Компанийн тухай хуульд заасан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох,
- 5.4.2 Компанийн аудиторыг сонгож түүнтэй хийх гэрээний нөхцлийг тогтоох,
- 5.4.3 Сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох,
- 5.5 ТУЗ-ийн хараат бус гишүүн нь дараах нэмэлт эрхтэй байна. Үүнд:
- 5.5.1 ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь Компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлсөн эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм журамд нийцсэн эсэхэд хяналт тавих, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил илэрсэн тохиолдолд түүнийг арилгуулахаар холбогдох албан тушаалтанд шаардлага тавих, шаардлагыг эс биелүүлбэл уг асуудлыг ТУЗ-д тавьж шийдвэрлүүлэх, улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шаардлагыг хүргүүлэх;
- 5.5.2 Компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;
- 5.5.3 Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, ТУЗ-ийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах, тодруулга хийх.

#### **Зургаа. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга**

- 6.1. ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн нийт гишүүдээс олонхын саналаар сонгоно.
- 6.2. ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих, үнэн зөвийг хариуцаж ажиллах үүрэгтэй байна.
- 6.3. ТУЗ-ийн даргыг түр эзгүйд түүний үүргийг ТУЗ-ийн даргын томилсон эсхүл ТУЗ-ийн шийдвэрлэсэн аль нэг гишүүн гүйцэтгэнэ.
- 6.4. ТУЗ-ийн дарга нь Компанийн гүйцэтгэх захирал байхыг хориглоно.

#### **Долоо. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга**

- 7.1 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (цаашид “Нарийн бичгийн дарга” гэх) нь компанийн эрх бүхий ажилтан байна.
- 7.2 Нарийн бичгийн даргыг ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилох бөгөөд бүрэн эрхийн хугацаа нь гурван жил байна.
- 7.3 Нарийн бичгийн дарга нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гурав болон түүнээс дээш удаа хуралд оролцоогүй, албан үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд оролцоогүй хугацаан дахь цалин, урамшууллыг олгохгүй.
- 7.4 Нарийн бичгийн дарга нь Компанийн тухай хууль, Компанийн дүрэм болон энэхүү журамд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд сануулах, үндсэн цалинг нэг удаа 20 хүртэл хувиар бууруулах, нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөх хүртэл арга хэмжээ авч болно.
- 7.5 ТУЗ-ийн даргын эзгүйд нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн даргыг орлох эрхтэй ба дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
- 7.5.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлын болон ТУЗ-ийн бичиг хэргийг хариуцан хөтлөх, хувьцаа эзэмшигчид мэдээлэл хүргэх;

- 7.5.2 Хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн хурлын бэлтгэлийг хангах, хурлын зар, хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл болон гарах шийдвэрийн төсөл, бусад баримт бичгийг зохих журмын дагуу бэлтгэх, хүргэх ажлыг зохион байгуулах;
- 7.5.3 Хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн хурлын тэмдэглэл хөтлөх, гарах шийдвэрийг зохих журмын дагуу баталгаажуулах, хэрэгжилтэнд хяналт тавих;
- 7.5.4 Компанийн хууль тогтоомжоор хүлээсэн нийтэд мэдээлэх шаардлагатай үйл явдал, өөрчлөлт бий болсон тохиолдолд тухай бүр ажлын нэг хоногийн дотор мэдээлэх, холбогдох төрийн байгууллагуудад хууль тогтоомжид заасан журмын дагуу хүргүүлэх;
- 7.5.5 Хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ, гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах ажлыг зохион байгуулах;
- 7.5.6 ТУЗ-ийн бусад дотоод үйл ажиллагааг хариуцан ажиллах.
- 7.6 Нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд дараах зүйлийг тусгана:
  - 7.6.1 Хурал хийсэн газар болон өдөр, цаг;
  - 7.6.2 Хуралд оролцсон гишүүд;
  - 7.6.3 Хурлаар хэлэлцсэн асуудал;
  - 7.6.4 Санал хураалтаар шийдвэрлэсэн асуудал болон санал хураалтын дүн;
  - 7.6.5 Гаргасан шийдвэр;

#### **Найм. Төлөөлөн удирдах зөвлөлийн хороод**

- 8.1. Компани нь 1) Корпорацийн засаглал, соёлын хороо, 2) Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо, 3) Аудит, эрсдэлийн хороо гэсэн гурван хороодтой (цаашид “Хороо” гэх) байна.
- 8.2. Хороо тус бүр нь 3 хүний бүрэлдэхүүнтэй байна.
- 8.3. Компани нь шаардлагатай гэж үзсэн тохиолдолд ТУЗ-өөс түр хороог байгуулан ажиллуулж болно.
- 8.4. Хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байх бөгөөд Аудит, эрсдэлийн хорооны дарга нь санхүү, бүртгэл, эрсдэлийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн хараат бус гишүүн байна.
- 8.5. Хорооны гишүүдийг ТУЗ-өөс томилох ба ТУЗ-ийн гишүүдээс гадна Компанийн ажилтнууд болон тухайн асуудлаар мэргэшсэн гадны хүнийг өөртэй нь тохиролцсоны үндсэн дээр туслуулахаар томилж болно.
- 8.6. Хороо нь Компанийн дүрэм болон холбогдох журамд заасан тодорхой чиг үүрэгтэй байх бөгөөд тухайн асуудлаар дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулах, хуульд заасан зарим асуудлаар шийдвэр гаргах бүрэн эрхтэй байна.
- 8.7. Энэ журмын 8.1-д заасан хороодын үйл ажиллагааны журам, эрх, үүргийг хороод тус бүрийн журмаар зохицуулах бөгөөд уг журмуудыг ТУЗ батална.

#### **Ес. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн үүрэг хариуцлага**

- 9.1 ТУЗ-ийн гишүүд нь өөрт олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Компанийн ашиг сонирхолд нийцүүлэн үнэнч шударга ажиллах үүрэгтэй.
- 9.2 ТУЗ-ийн гишүүд нь Компанийн үйл ажиллагааны талаар шууд болон шууд бус аргаар олж авсан мэдээ мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд ашиглахгүй байх, задруулахгүй байх үүрэгтэй.
- 9.3 ТУЗ-ийн гишүүд нь өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээдийн Компани болон Компанитай нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийсэн болон хийхээр төлөвлөж буй гэрээ хэлцлийн талаар мэдээлж байх үүрэгтэй.
- 9.4 ТУЗ-ийн гишүүний буруутай үйл ажиллагааны улмаас Компанид хохирол учирсан тохиолдолд уг хохирлыг хариуцах үүрэгтэй.